



# ЖИЛИЙН ТАЙЛАН

## 2021

**БидисЕК Brokerage**

## АГУУЛГА

1. ТУЗ-ийн даргын мэндчилгээ
2. Оны онцлох ажлууд
3. Компанийн ерөнхий мэдээлэл
4. Компанийн үйл ажиллагаа
5. Компанийн засаглал
6. Санхүүгийн тайлан



**Б.Лхагвадорж**  
Төлөөлөн удирдах  
зөвлөлийн дарга

*Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч,  
хөрөнгө оруулагч харилцагч нар аа!*

Та бүхэнд БиДиСЕК ҮЦК ХК-ийн 2021 оны жилийн тайланг танилцуулж байгаадаа таатай байна. Хэдийгээр бид цар тахлын хүнд хэцүү цаг үед ажиллаж байгаа ч манай компанийн хувьд харилцагчдад хүргэх үйлчилгээний чанарыг сайжруулж, зах зээлд шинэ бүтээгдэхүүнүүдийг санал болгосон амжилт ололтоор дүүрэн түүхэн жил байлаа.

Бид өнгөрсөн жил Дэлхийн банк санхүүгийн зах зээлийн томоохон төлөөлөгчдийн нэг болох “Global Banking and Finance Review” буюу “Дэлхийн Банк Санхүүгийн Тойм” байгууллагаас жил бүр зохион байгуулдаг “Global Banking and Finance Review Awards”-н “Монгол Улсын шилдэг брокер, дилерийн компани”, “Монгол Улсын шилдэг хөрөнгө оруулалтын банк”-аар шалгарав.

2021 онд Эрдэнэс-Тавантолгой Хаалттай ХК-ийн Монгол Улсын санхүүгийн салбар дахь хамгийн их дүн буюу 2 их наяд төгрөг хүртэлх нээлттэй өрийн бичиг гаргах ажиллагаанд тэргүүлэх андеррайтераар ажиллаж байна.

Мөн ХААН Банкны IPO ажиллагаанд андеррайтераар сонгогдон, Монголбанканд хувьцаат компани болох төлөвлөөгөө батлуулсан, Канад улсын Торонтогийн хөрөнгийн бирж болон Монголын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент ХК-ийн нэмэлт хувьцааг гаргах ажиллагаанд андеррайтераар ажиллан 14.25 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн зэрэг томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Брокерийн үйл ажиллагааны хувьд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан үйл ажиллагаагаа илүү дижитал технологи дээр суурилан явуулахыг эрмэлзэж, онлайнаар данс нээх, гэрээ байгуулах, захиалга өгөх зэрэг нөхцөлүүдийг бүрдүүлэн онлайн арилжааг шимтгэлгүй болгосноор онлайн харилцагчийн тоо 127 хувиар, онлайн хэлцлийн тоо 9 дахин нэмэгдсэн байна.

Мөн компани нь олон улсын SAXO банкны Монгол улс дахь албан ёсны цор ганц дамжуулагч брокерын хувьд SAXO банкаар дамжуулан 6.4 сая долларын арилжаа хийсэн нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 103 хувийн өсөлтийг үзүүлжээ.

2022 онд бид ХААН Банкны энгийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагаатай уялдуулан харилцагчийн цар хүрээгээ тэлэх бодлого баримтлан, хөрөнгийн зах зээлд чанартай бүтээгдэхүүнүүдийг санал болгон олон улсын жишигт нийцүүлэн ажиллахыг зорьж байна.

**1 CAP**

ЭТТ Бондын үндсэн андеррайтераар ажиллах гэрээнд гарын үсэг зурав.

**2 CAP**

МХБ-ээс ТХБ рүү “Эрдэнэ Ресурс” ХК-ийн хувьцаа чөлөөтэй хөрвөдөг болов.

Саксо Банкны анхны хөрөнгө оруулалт 2000\$-оос 100\$ болж буурав.

**3 CAP**

ЭТТ Бонд 3 үе шаттайгаар гарах зөвшөөрлийг СЗХ-оос авсан.

**4 CAP**

ЭТТ Бонд I үе шатын анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хийгдэв. Global Banking Finance Awards 2021 сэтгүүлийн Монгол Улсын шилдэг Хөрөнгө оруулалтын банк, шилдэг Брокер, дилерийн компаниар шалгарав.

**5 CAP**

ХААН Банкны IPO гаргах үйл ажиллагаанд үндсэн андеррайтераар ажиллах гэрээнд гарын үсэг зурав.

**6 CAP**

ХААН Банкны хувьцаагаа нийтэд санал болгох төлөвлөгөөг Монголбанкинд хүргүүлэв.

**7 CAP**

Global Banking Finance review сэтгүүлд компанийн мэдээлэл нийтлэгдэв.

**8 CAP**

ЭТТ Бондын II үе шатын анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хийгдэв.

ХААН Банкны нээлттэй хувьцаат компани болох төлөвлөгөөг Монголбанк зөвшөөрөв.

**9 CAP**

БиДиСЕК ҮЦК нь Биржийн бус зах зээлийн шууд гишүүнээр элсэв.

**10 CAP**

МХБ, ТХБ-д давхар бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент ХК-ийн МХБ дээр нэмэлт хувьцаа гарган 14.25 тэрбум төгрөгийн санхүүжилт татах ажиллагаанд андеррайтераар ажилласан.

**11 CAP**

Ехро 2020 Dubai – д оролцсон.

**12 CAP**

Ачит Зэс ХХК-ийн ажилчдад давуу эрхийн хувьцаа эзэмшүүлэх төсөл нь амжилттай хэрэгжиж дууслаа.

Global Banking & Finance Review компанийн  
Global Banking Finance Awards 2021

шалгаруулалтад Монгол Улсын

**“ШИЛДЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК”,**

**“ШИЛДЭГ БРОКЕРИЙН КОМПАНИ”**-иар

шалгарав.



“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ийн 2 ИХ  
НАЯД төгрөг хүртэлх нээлттэй бонд гаргах  
ажиллагаанд тэргүүлэх андеррайтераар  
ажиллаж байна.



“ХААН БАНК” ХХК-ийн IPO ажиллагаанд  
андеррайтераар хамтран ажиллах гэрээ  
байгуулав.



“ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ  
КОРПОРАЙШН” ХК-ийн FPO ажиллагаанд  
андеррайтераар хамтран ажиллах гэрээ  
байгуулав.



Монголын хөрөнгийн биржийн нийт  
арилжааны 38 хувийг дангаараа гүйцэтгэв.



Гадаад арилжааны зуучлал:  
Харилцагчдын тоо 22 ХУВИАР өсч,  
+\$3 САЯ арилжаа хийгдлээ.

## АЛСЫН ХАРАА

Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, технологид суурилсан санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжиж чинээлэг харилцагч, нийгмийн баялаг үнэт зүйлийг бий болгох.

## ЗОРИЛГО

### Урт хугацаанд

Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах, үндэсний томоохон хувьцаат компаниудыг шинээр бий болгох;

### Дунд хугацаанд

Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг дэмжих, олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаагаа явуулах, хөрөнгийн зах зээлд оролцогчдын хүрээг нэмэгдүүлэх;

### Богино хугацаанд

Гадаад харилцааг өргөжүүлэх, үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, компанийн боловсон хүчнийг чадваржуулах, харилцагчдыг хөрөнгийн зах зээлийн мэдээгээр найдвартай хангах;

## ҮНЭТ ЗҮЙЛС



### PIONEERS IN CAPITAL MARKET

/Зах зээлийн  
анхдагч/



### LOYALTY TO OUR CLIENTS

/Харилцагч  
төвтэй/



### PROFESSIONALISM

/Мэргэжлийн  
хандлага/



### TRANSPARENCY

/Ил тод нээлттэй  
байдал/



### PRUDENCE

/Боломжийг бүрэн  
ашиглах чадвар/



# КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**2021**


## ХАРИЛЦАГЧИЙН БААЗ СУУРЬ

БиДиСЕКУЦК нь Монголын хөрөнгийн зах зээлд дээрх нийт харилцагчдын 10.7% нь манай компаниар үйлчлүүлж байна.



## Данс нээсэн тоо /өссөн дүнгээр/:

Эрдэнэс-Тавантолгой ХК нь 1072 хувьцааны ногдол ашиг тараасантай холбоотой дийлэнх иргэд үнэт цаасны дансаа нээлгүүлсэн. БиДиСЕКУЦК ХК-д 2021 оны эцсийн байдлаар нийт 263,295 иргэдийн данс бүртгэлтэй байна.






## БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид өөрсдийн харилцагч, хөрөнгө оруулагч нартаа Монголын Хөрөнгийн зах зээл дээрээс хувьцаа, бонд худалдах, худалдан авах арилжаанд зуучилж, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг хүргэхээс гадна олон улсын хөрөнгийн биржээс үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах цогц үйлчилгээг хүргэж байна.


### Нийт арилжаа /тэрбум төгрөг/:

2021 онд МХБ дээр нийт 2.7 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэн ба үүний 38%-ийг “Бидисек ҮЦК” ХК нь дангаараа гүйцэтгэсэн байна.



### Анхдагч зах зээлийн арилжаа 2021 он /тэрбум төгрөг/ :


2021 онд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд нийт 2 компани IPO хийж, 1 компани нэмж хувьцаа гаргаж, 1 хамтын ХОС байгуулагдаж, 7-н ширхэг нээлттэй бондын арилжаа зохион байгуулагдсан. Компани нь ЭТТ 2 их наяд хүртэлх нээлттэй бондын тэргүүлэх андеррайтераар ажилласан ба энэхүү ажиллагаатай холбоотой анхдагч зах зээлийн 60.6 хувийг дангаараа гүйцэтгэсэн үзүүлэлттэй байна.



## ОНЛАЙН БРОКЕР:

Харилцагчид нь вэб хөтчөөр болон гар утас, компьютер ашиглан ХААНААС Ч, ХЭЗЭЭ Ч Монголын Хөрөнгийн Биржийн арилжаанд оролцох, захиалгаа илгээх, дансны үлдэгдэл харах, гүйлгээ хийх боломжтой.

	2020	2021
Онлайн харилцагч /12.17 байдлаар/	1,072	2,431
Нийт арилжаанд оролцсон харилцагчдын тоо	769	1121
Онлайнаар арилжаанд оролцсон харилцагчдын тоо	387	971
Онлайнаар ирүүлсэн захиалгын тоо	3,898	2,8325
Онлайнаар авсан захиалгын дүн, тэрбум төгрөг	3.06	8.87



Авах захиалга		Зарах захиалга		Биелсэн хэлцлүүд		
Авах үнэ	Авах тоо ширсэг	Зарах үнэ	Зарах тоо ширсэг	Огноо	Үнэ	Тоо ширсэг
4,800.00	94	4,975.00	37			
4,800.00	10	4,999.00	24			
4,800.00	10	4,999.00	234			
4,755.00	10	5,000.00	60			
4,753.00	200	5,000.00	30			
4,752.00	80	5,000.00	30			
4,751.00	50	5,000.00	30			
4,750.00	200	5,000.00	30			
4,702.00	10	5,000.00	6			
4,700.00	300	5,000.00	33			

Захиалга өгөх		Дансны үлдэгдэл: 275.70 ₮
Авах/Зарах*	Авах	
Захиалгын төрөл*	Нөхцөлт	
Үнэ*	Үнэ	
Тоо ширсэг*	Тоо ширсэг	
Хугацаа*	Захиалга цуцлагдах хүртэл	
Шингэл	1.00%	
Нийт (Дүн + Шингэл)	0	

БиДиСЕК ҮЦК ХК-ийн онлайн арилжааны систем, гар утасны аппликэшн нь дараах цэсийг багтаасан:

- ✓ Хяналтын самбар
- ✓ Дансны хуулга
- ✓ Гүйлгээний түүх
- ✓ Үлдэгдэл
- ✓ Өгөөжийн тооцоолол
- ✓ Ашгийн тооцоолол
- ✓ Миний багц /демо арилжаа/
- ✓ Арилжаа

## ИНСТУТЦИОНАЛЬ ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

СЗХ-оос 2017 оны 05 сарын 11-ний өдөр “Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа”-ны зөвшөөрөл авснаар дотоодын харилцагчдадаа олон улсын зах зээл дэх үнэт цаасны арилжаанд оролцох бололцоог бүрдүүлсэн. Тус үйлчилгээний хүрээнд олон улсын тэргүүлэгч онлайн брокер Саксо Групптэй хамтран ажиллаж байна.

### Харилцагчид

Данс нээсэн  
харилцагчийн тоо:  
22 хувиар өсөв.

### Арилжаа

103 хувиар  
нэмэгдэв.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АЙЛЧЛАЛ:

Тайландын тэргүүлэгч даатгалын компаниудын нэг болох Muang Thai Insurance-ийн Монгол дахь айлчлал мөн гадаад хөрөнгө оруулагч болон Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй томоохон хувьцаат компаниуд хооронд цахим уулзалтуудыг амжилттай зохион байгуулав.



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АЙЛЧЛАЛ:

## CONFERENCE CALLS

- BNP Paribas
- Raffles
- AFC
- Wood&Company
- Amstel
- GFM Gossak Bond Company
- AGCO
- Frontaura
- RWC

ARRANGED CONFERENCE  
CALLS FOR:

- Impera Capital
- Isaac
- MUFG
- Sumitomo Mitsui Banking Corporation



## MEETING IN PERSON:

- Daniel Paul Stein
- USA Embassy
- Mongolian Chinese Center

## БИРЖ ХООРОНД ДАХЬ ХУВЬЦАА ХӨРВҮҮЛЭГ:

Санхүүгийн Зохицуулах Хороо 2020 оны 08 сарын 12-ны өдөр “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол улсад үнэт цаас гаргах, Монголын улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам” -ыг шинэчлэн баталсан ба уг журмын шинэчлэлтээр давхар бүртгэгдсэн компанийн хувьцаа Монгол, гадаад биржүүд хооронд хөрвөн арилжаалагдах зохицуулалтыг тусгаж өгсөн.

Энэ хүрээнд “БиДиСЕК ҮЦК” ХК нь 2021 оноос эхлэн Монгол болон Торонтогийн Хөрөнгийн Биржид давхар бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК-ийн хувьцааг 2 биржийн хооронд хөрвүүлэх ажлыг амжилттай гүйцэтгэж байна.

## BACK OFFICE ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номинал дансаар төлбөр тооцоо гүйцэтгэх, харилцагчдын мөнгөн хөрөнгийн гүйлгээг цаг тухайд нь хийх, хянах үйл ажиллагааг Компанийн Backoffice алба хариуцан гүйцэтгэж байна.



### Эрдэнэс-Тавантолгой ХК Нээлттэй бонд

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1 их наяд гаруй төгрөгийн дүнтэй анхдагч зах зээлийн арилжааны бүртгэл, тооцоолол, мөнгөн шилжүүлэгтэй холбоотой ажлуудыг гүйцэтгэв.



### Банк хоорондын USD гүйлгээ

Ам.доллараар илэрхийлэгдсэн үнэт цаасыг арилжаалж эхэлсэнтэй холбогдуулан Монгол банкны гүйлгээний системээр дамжуулан банк хоорондын ам.долларын гүйлгээг шилжүүлэхтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэв.



### Системийн голлох банкууд дээрх номинал данс

Харилцагчид сонголт бий болгох зорилгоор санхүүгийн системийн голлох банкуудад номинал данс нээлгэж, гүйлгээ хийхэд бэлтгэв.



### Үнэт цаасны номинал данс

Хорооны зохицуулалтын хүрээнд үнэт цаасны номинал данс нээлгэх шаардлага, шалгууруудыг хангаж, материалуудыг бүрдүүлэн ажиллаж байна.

## АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“БиДиСЕК ҮЦК” ХК нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил, үйлдвэржилтэнд хувь нэмэр оруулахуйц үндэсний үйлдвэр, компаниудад хөрөнгө оруулалт татахад нь бүхий л талаар дэмжин ажиллаж байгаа ба Монголын хөрөнгийн зах зээл дээр шинээр гаргасан хувьцаа болон бондын андеррайтераар ажиллаж, энэ чиглэлээр ихээхэн туршлага хуримтлуулсан.

## 2021 ОНД СУДАЛСАН ТӨСЛҮҮД:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЛБА 2021 ОНД СУДАЛСАН НИЙТ ТӨСӨЛ



**39**  
хувь

Зөвлөгөө, мэдээлэл  
хүргэсэн төсөл



**21**  
хувь

Шалгуур үзүүлэлтийг  
хангаагүй буцаасан  
төсөл

**38**

төсөл хүлээн  
авч судалсан.



**24**  
хувь

Саналаа татсан,  
хойшилсон, цуцалсан  
төсөл



**16**  
хувь

Амжилттай гэрээ  
байгуулсан,  
хэрэгжүүлэхээр  
ажиллаж буй төсөл

## АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“БиДиСЕК ҮЦК” ХК нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил, үйлдвэржилтэнд хувь нэмэр оруулахуйц үндэсний үйлдвэр, компаниудад хөрөнгө оруулалт татахад нь бүхий л талаар дэмжин ажиллаж байгаа ба Монголын хөрөнгийн зах зээл дээр шинээр гаргасан хувьцаа болон бондын андеррайтераар ажиллаж, энэ чиглэлээр ихээхэн туршлага хуримтлуулсан.

### 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД:



2 ИХ НАЯД төгрөг  
хүртэлх нээлттэй  
өрийн бичиг

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 03 сарын 26-ны өдрийн 96 тоот тогтоолын хүрээнд Эрдэнэс Тавантолгой ХК нь 2 их наяд төгрөг хүртэлх нээлттэй өрийн бичгийг нийтэд санал болгох зөвшөөрлийг авсан билээ.

Эрдэнэс Тавантолгой ХК нь уг зөвшөөрлийн хүрээнд 3 үе шат бүхий 1 их наяд төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

Энэхүү санхүүжилтээр компани нь Засгийн газраас 2020-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Тавантолгой дулааны цахилгаан станц, нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамж, төмөр зам зэрэг үндэсний томоохон бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэх юм.

Уг ажиллагаанд БиДиСЕК ҮЦК ХК нь тэргүүлэх андеррайтераар ажиллаж байна.



**ХААН БАНК**

IPO ажиллагаа

2021 оны 01 сарын 29-ний өдрийн “Банкны тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлтөөр банкны системд нөлөө бүхий 5 банк хуулийн зохицуулалтын дагуу 2022 оны 06 сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болж, хөрөнгийн зах зээлд 20 хүртэлх хувиа санал болгон IPO гаргасан байх үүрэг хүлээсэн. Уг хуулийн зохицуулалтын дагуу “Хаан Банк” ХХК нь 2021 оны 03 сарын 02-ны өдөр “Андеррайтерийн сонгон шалгаруулалтын тендер” зарласан. Энэхүү сонгон шалгаруулалтын хүрээнд БиДиСЕК ҮЦК ХК нь андеррайтераар сонгогдсон бөгөөд талууд 2021 оны 05 сарын 05-ны өдөр 544 тоот дугаартай “Андеррайтерийн болон хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулсан.

Уг ажиллагааны хүрээнд Монголбанкнаас хувьцаа гаргах төлөвлөгөөг хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авсан ба одоогийн байдлаар бусад бэлтгэл ажлууд хийгдэж байна.

## 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД:



Нэмэлт хувьцаа  
гаргах ажиллагаа

Монголын анхны давхар бүртгэлтэй хувьцаат компани болох Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 09 сарын 22-ны өдрийн 80 тоот тогтоолын дагуу 14,250,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий нэмэлт хувьцааг нийтэд санал болгосон ба уг ажиллагаанд БиДиСЕК ҮЦК нь тэргүүлэх андеррайтераар ажиллалаа.



Давуу эрхийн  
хувьцаа эзэмшүүлэх  
хөтөлбөр

Ачит Зэс ХХК нь өөрийн болон Эрдэнэт үйлдвэрийн ажилчдад өндөр өгөөж бүхий Давуу эрхийн хувьцааг санал болгосноороо Монголдоо анхдагч томоохон төсөл юм. БиДиСЕК нь 2018 оноос хойш уг төсөлд Зөвлөхөөр ажиллаж байна. ҮЦТХТ-ийн бүртгэлээс хасах гүйлгээ хийгдсэнээр төсөл амжилттай хэрэгжиж дуусаад байна.



Өрийг хувьцаагаар  
солих хөтөлбөр

2021 оны 2-3 сард Хот Девелопмент ХК-ийн өрийг хувьцаагаар солихыг зөвшөөрсөн МХБ, СЗХ-ны тогтоол гарсан.





Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах вэб аппликэйшнийг өөрсдөө хөгжүүлснээр 6 хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг онлайн хэлбэрээр амжилттай зохион байгууллаа.

[www.agm.bdsec.mn](http://www.agm.bdsec.mn)



Цар тахалтай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдийн хурлыг онлайнар зохион байгуулах платформыг нэвтрүүлэв.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН КОМПАНИУД

**APU COMPANY**

Absolute. Pure. Unique.

АПУ ХК

**ERDENE**  
RESOURCE DEVELOPMENT

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ  
КОРПОРАЙШН ХК



**БОДЬ ДААТГАЛ**  
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

БОДЬ ДААТГАЛ ХК



ХӨХ ГАН ХК



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК



ГОВИЙН ӨНДӨР ХК

БАЯН ТЭЭГ ХК

## САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮР ДҮН, 2021

Нийт хөрөнгө

**25.4** тэрбум  
төгрөг

Өсөлт (2020-2021): 2.4%

Нийт өр төлбөр

**7.3** тэрбум  
төгрөг

Бууралт (2020-2021): 12%

Нийт үйл ажиллагааны  
орлого**3.7** тэрбум  
төгрөг

Өсөлт (2020-2021): 1.9x

Цэвэр ашиг

**1.6** тэрбум  
төгрөг

Өсөлт (2020-2021): 3.6x

## САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Харьцаа үзүүлэлтүүд	2018 он	2019 он	2020 он	2021 он
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	110.32	1.46	(49.43)	119.35
Зах зээлийн үнэ ба бүртгэлийн үнийн харьцаа (ЗЗҮ/БҮ)	0.72	0.68	0.76	0.90
Үнэ ашгийн харьцаа (P/E)	8.19	583.94	n/a	9.97

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Жил бүр мод тарих аяны хүрээнд компани нь – жилдээ мэргэжилтнүүдийг уриалан мод тарьлаа.



Коронавируст цар тахлын эрсдэлээс сэргийлсэн “Нэг өрх-Нэг иргэн” аянд БиДиСЕК ҮЦК нь өөрсдийн хувь нэмрээ оруулсан.




# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ




Компанийн засаглал нь гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын хоорондох цогц харилцаа бөгөөд компанийн стратеги, алсын хараа болон зорилтыг тодорхойлох, тэдгээр зорилтод хүрэх арга зам, гүйцэтгэлийг хянах тогтолцоог бий болгодог.

## ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ



## НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД


№	Нэр	Эзэмшлийн хувь
1	Д.Даянбилгүүн	14.2%
2	БиДиСЕК ҮЦК ХК	19.44%
3	Монголиан Мастер Менежмент ХХК	6.96%
4	Тасган Инвест ХХК	12.61%
5	Zwahr Alexander	19.79%

## НОГДОЛ АШИГ

БиДиСЕК ҮЦК ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 02 сарын 18-ны өдрийн 01/2022 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 50 төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэрлэсэн.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоож, 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор “ҮЦТХТ” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн.

## ХУВЬЦААНЫ ХАНШ /2021.01.01-2021.12.31/



## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

МХБ-ийн ангилал	I ангилал
Хаалтын ханш /2022.03.09/:	1,130₮
Зах зээлийн үнэлгээ:	17,625,314,421₮
Нийт эргэлтэнд гаргасан: хувьцааны тоо:	13,694,883
52 хоног	791₮-1,366₮

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

БиДиСЕК ҮЦК ХК-ийн эрх барих дээд байгууллага нь “Хувьцаа эзэмшигчдийн хурал” юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн стратегийн ач холбогдолтой шийдвэрүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, ногдол ашгийн бодлого тодорхойлох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, компани дээр хийгдэж буй хэлцлүүдийг хянах, бизнес төлөвлөгөөг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

БиДиСЕК ҮЦК ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 10:00 цагт компанийн байранд цахим хэлбэрээр/онлайнаар зохион байгуулагдав. Дэлхий даяар үүссэн нөхцөл байдал, COVID 19-тэй холбоотой хөл хорионы улмаас компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хоёр дахь удаагаа онлайнаар амжилттай зохион байгуулсан. Хуралд 62.80 хувийн саналын эрхтэй нийт 22 хувьцаа эзэмшигч оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан бөгөөд нийт 4 асуудлыг хэлэлцэж батлав.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнав.
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн ТУЗ-ийн дүгнэлтийг 99.64 хувийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн 2021 оны төсвийг 99.64 хувийн саналаар батлав.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг олонхын саналаар батлав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар зохион байгуулахтай холбоотой бид жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах, хязгаарлахгүй байх талд анхаарч ажилласан бөгөөд олон нийтийн хэрэгслээр мэдээлэл өгөх, урьдчилан санал авах, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг өөрийн компанийн байр болон бусад үнэт цаасны компаниудаар дамжуулан санал өгөх эрхийг хангаж ажилласан.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Пассин нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ өгснөөр ТУЗ-ийн 2021 оны 10 сарын 20-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрээр чөлөөлсөн. Иймд компанийн ТУЗ нь одоогоор 8 гишүүнтэй бүрэлдэхүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүд нь 2021 оны 03 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон.

### ТУЗ-ИЙН ДАРГА



**Б.Лхагвадорж**  
БиДиСЕК ҮЦК ХК,  
Тэргүүн дэд захирал

### ЕРДИЙН ГИШҮҮД



**Д.Даянбилгүүн**  
БиДиСЕК ҮЦК ХК,  
Гүйцэтгэх захирал



**Н.Батгэрэл**  
БиДиСЕК ҮЦК ХК,  
Дэд захирал



**Улуч Бингол**  
Импера Капитал  
Дэд ерөнхийлөгч

### ХАРААТ БУС ГИШҮҮД



**Хитоши Тани**  
EXE корпораци  
Ерөнхийлөгч



**Д.Амгаланбаяр**  
MSM ХХК,  
Захиргааны  
мэргэжилтэн



**Б.Амарсанаа**  
Хэрэжи ХХК,  
Гүйцэтгэх  
захирал



**Б.Энхбаяр**  
Sanaa EXE ХХК,  
Гүйцэтгэх  
захирал



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх түр хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон. Үүнд:

### Нэр дэвшүүлэх дэд хороо:

Дарга:	Д.Даянбилгүүн	Ердийн гишүүн
Гишүүд:	Улуч Бингол	Ердийн гишүүн
	Б.Энхбаяр	Хараат бус гишүүн

### Аудитын хороо:

Дарга:	Хитоши Тани	Хараат бус гишүүн
Гишүүд:	Д.Амгаланбаяр	Хараат бус гишүүн

### Цалин урамшууллын хороо:

Дарга:	Н.Батгэрэл	Ердийн гишүүн
Гишүүд:	Б.Амарсанаа	Хараат бус гишүүн
	Д.Амгаланбаяр	Хараат бус гишүүн

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Компани нь 2021 онд гадаад болон дотоодын санхүү, хөрөнгийн зах зээл дээр олон жилийн туршлагатай зөвлөхүүдийг урьж ажиллуулж, компанийн мэргэжилтнүүдтэй харилцан туршлага солилцон томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

Одоогийн байдлаар компани дараах гишүүдийн бүрэлдэхүүнтэй гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байна.

№	Нэр	Албан тушаал	ХЗЗ-д ажилласан жил
1	Б.Лхагвадорж	БиДиСЕК ҮЦК ХК-ийн Тэргүүн дэд захирал	25
2	Д.Даянбилгүүн	БиДиСЕК ҮЦК ХК-ийн гүйцэтгэх захирал	25
3	Н.Батгэрэл	БиДиСЕК ҮЦК ХК-ийн дэд захирал	25
4	А.Зориг	Зөвлөх	8
5	Ш.Шинэбаяр	Хөрөнгө оруулалтын албаны менежер	14
6	С.Дамдинсүрэн	IT албаны менежер	12
7	С.Пүрэвсүрэн	Дотоод албаны менежер	17
8	Б.Онон	Харилцагчийн албаны менежер	4
9	С.Дөлгөөн	Back office албаны менежерийн үүрэг гүйцэтгэгч	4





# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН (АУДИТЛАГДСАН)



Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам  
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770  
Факс:(976) 7014 1770

Огноо: 2022.02.18

№ 22/08

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### "БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Бид 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Би Ди Сек ҮЦК" ХК болон түүний охин компани "Би Ди Си Эй Пи" ХХК, "Их Чингис Хааны хөмрөг" ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 12-27 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

#### Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд нөлөөлөхүйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

#### Бусад мэдээлэл

Компани нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн багалгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм. АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан. Мөн бид засаглах удирдлагад аудиторын

хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

#### Номинал дансны талаар

"Би Ди СеК ҮЦК" ХК нь өөрийн нэр дээр Голомт банкин дах 1105057130 тоот төгрөгийн данс, 1105391344 тоот ам. долларын данс, Худалдаа хөгжлийн банкин дах 452644001 тоот ам.долларын дансаар тус тус дамжуулан өөрийн харилцагчдын МХБ-н арилжааны хэлцлээс үүдэлтэй төлбөр тооцоог валют тус бүрээр ялган гүйцэтгэсэн байна.

Ингэхдээ Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-н 6.2.8, болон 6.2.9, шаардлагуудыг тус тус ханган ажиллаж, холбогдох хууль тогтоомжид заасан зохицуулалтыг мөрдөн ажиллаж байгаа нь гүйлгээний баримт, харилцагчийн арилжааны захиалгын гэрээ зэрэг анхан шатны баримтуудаар нотлогдож байна.

Тус журмын 6.2.5-д заасны дагуу компани нь харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан, балансын гадуур бүртгэж, өөрийн эргэлтийн хөрөнгө болон, өөрийн хөрөнгийн зохист харьцаанд хамааруулан тооцдоггүй нь компанийн санхүүгийн байдлын тайлангаас харагдаж байна.

Харилцагчдын нэр дээр хийгдсэн орлого болон зарлага, арилжааны хэлцэлтэй холбоотой мөнгөн гүйлгээний мэдээллийг дэлгэрэнгүй хөтөлж, бүртгэлд үнэн зөв тусгасан бөгөөд холбогдох зохицуулалтын хүрээнд харилцагчдын гүйлгээтэй холбоотой дэлгэрэнгүй тайланг сар тус бүрээр гарган, зохицуулагч байгууллагуудад хүргэн ажилласан байна. Бид аудитын горимын дагуу дээрх арилжааны банкинд байрших номинал данснуудад тулган баталгаажуулалтыг хийхэд ямар алдаа зөрчил гараагүй байна.

Компани нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай" хуулийн 4.1-т заасан "Мэдээлэх үүрэгтэй этгээд"-ийн хүлээсэн үүргийн хүрээнд номинал дансаар дамжин харилцагчдын дансанд хийгдсэн их дүнтэй гүйлгээний мэдээллийг Монгол Банк болон Санхүүгийн Зохицуулах Хороонд тухай бүр болон улирал тутамд тогтмол цахим болон цаасан хэлбэрээр тайланг хүргүүлэн ажилласан байна.

"Би Ди СеК ҮЦК" ХК-ний харилцагчдын арилжааны төлбөр тооцоотой холбоотой мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах зорилго бүхий номинал дансны харилцагчийн мөнгөн гүйлгээний тайланг банкны хуулга болон анхан шатны баримт, мөнгөн хөрөнгө дамжсан данс бүрээр нь тулган шалгахад Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам", байгууллагын "Харилцагчийн мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо, гүйлгээний журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв хөтөлсөн байна.

#### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу "Би Ди СеК ҮЦК" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

"Пантер Мидланд Аудит" ХХК  
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг

"Пантер мидланд аудит"

5

## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН (аудитлагдсан)

№	Балансын үзүүлэлт	2021.01.01	2021.12.31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	А.Эргэлтийн хөрөнгө		
1.1.1.	Мөнгөн хөрөнгө	556,683,957	1,774,085,786
1.1.2	Богино хугацаат хөрөнгө оруулалт	17,374,874,230	14,776,608,152
1.1.3	Авлага	2,264,389,712	4,312,413,667
1.1.4	Бараа материал		-
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	15,456,000	17,501,556
1.1	Эргэлтийн хөрөнгийн дүн	20,211,403,899	20,880,609,161
1.2.	Б.Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,530,923,320	4,414,284,292
1.2.3	Биет бус хөрөнгө	16,014,750	12,547,915
1.2.	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,547,938,070	4,477,832,207
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,759,341,968</b>	<b>25,358,441,368</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>1,115,325,107</b>	<b>3,024,175,512</b>
2.1.1.1	Дансны өглөг	422,091,025	1,459,162,834
2.1.1.2	Цалингийн өглөг	104,657,150	157,518,712
2.1.1.3	ААНОАТ өглөг	11,419,198	105,219,036
2.1.1.4	НӨАТ-ын өглөг	2,708,470	1,964,058
2.1.1.5	ХХОАТ-ын өглөг	27,617,768	35,712,630
2.1.1.6	ҮХХТ-ын өглөг	3,469,200	6,938,400
2.1.1.7	НДШ ийн өглөг	25,150,691	36,953,178
2.1.1.8	Ногдол ашгийн өглөг		-
2.1.1.9	Банкны богино хугацаат зээл	2,200,000	500,000,000
2.1.1.10	Векселийн өглөг	6,984,417	2,535,396
2.1.1.11	Нөөц (өр төлбөр)	41,084,649	41,084,649
2.1.1.12	Бусад өглөг /Номинал/	467,150,303	676,844,384
2.1.1.13	Урьдчилж орсон орлого	792,237	242,237
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>7,190,943,764</b>	<b>4,246,663,924</b>
2.1.2.1	Урт хугацаат векселийн өглөг		-
2.1.2.2	Урт хугацаат зээл	7,190,943,764	4,246,663,924
2.1.2.3	Урт хугацаат бондын өглөг		-
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг		-
2.1.2.5	Урт хугацаат өглөгийн хасагдуулга		-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>8,306,268,871</b>	<b>7,270,839,436</b>
2.3	2. Эзэмшигчдийн өмч	13,151,321,974	13,151,321,974
2.3.1	Өмч: а) төрийн		-
2.3.2	б) хувийн	1,369,488,300	1,369,488,300
2.3.3	Нэмж төлөгдсөн капитал	7,957,309,291	7,957,309,291
2.3.4	Дахин үнэлгээний нөөц	3,824,524,383	3,824,524,383
2.3.5	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,301,751,124	4,936,279,958
2.3.6	Эзэмшигчдийн өмчийн дүн	16,453,073,098	18,087,601,932
2.4	Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн	16,453,073,098	18,087,601,932
	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>24,759,341,968</b>	<b>25,358,441,368</b>

## ОРЛОГЫН ТАЙЛАН (аудитлагдсан)

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021.01.01	2021.12.31
<b>Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн</b>			
1.1.1	<b>Үйл ажиллагааны орлого:</b>	<b>1,562,344,314</b>	<b>3,378,231,351</b>
1.1.1.1	Брокерийн үйл ажиллагааны	390,738,396	474,456,409
1.1.1.2	Андеррайтерийн үйл ажиллагааны	529,184,583	1,384,304,210
1.1.1.3	Хөрөнгө оруулалт менежмент хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний орлого	448,623,830	760,911,103
1.1.1.4	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	193,797,505	758,559,630
1.1.1.5	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого		-
1.1.2	Хөрөнгө оруулалтын орлого	432,796,112	332,566,553
1.1.2.1	Компанийн бондын хүүгийн орлого	122,549	-
1.1.2.2	Ногдол ашгийн орлого	132,329,097	179,786,252
1.1.2.3	Бусад орлого	165,557,449	42,967,285
1.1.2.4	Түрээсийн орлого	134,787,017	109,813,015
1.1.1	<b>Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>1,995,140,425</b>	<b>3,710,797,904</b>
1.2	Борлуулсан хөрөнгө оруулалтын үнэт цаасны өртөг		-
1.3.	<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b>1,995,140,425</b>	<b>3,710,797,904</b>
1.4.	Үйл ажиллагаа /борлуулалт, ерөнхий удирдлага/-ын зардал	2,639,061,299	2,515,447,045
1.5	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(643,920,874)	1,195,350,858
2	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг / алдагдлын дүн/	38,810,318	562,195,037
3	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	(605,110,556)	1,757,545,895
3.1	Орлогын татварын зардал	16,952,466	123,017,061
4	Татварын дараахь ашиг /алдагдал/	(622,063,022)	1,634,528,835
5	Ердийн ажиллагааны ашиг /алдагдал/	(622,063,022)	1,634,528,835
6	<b>Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>(622,063,022)</b>	<b>1,634,528,835</b>



## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (аудитлагдсан)

ҮЗҮҮЛЭЛТ	2021.01.01	2021.12.31
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(601,838,461)	1,325,420,444
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,323,577,143)	6,479,442,405
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,429,516,517	(6,587,461,021)
Валютын ханшны зөрүү	608,182	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	504,709,095	1,217,401,829
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,974,862	556,683,957
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	556,683,957	1,774,085,786

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (аудитлагдсан)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,369,488,300.00	7,957,309,291.00	3,824,524,382.82	3,301,751,123.55	16,453,073,097.37
Залруулсан үлдэгдэл	1,369,488,300.00	7,957,309,291.00	3,824,524,382.82	3,301,751,123.55	16,453,073,097.37
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	1,634,528,834.63	1,634,528,834.63
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,369,488,300.00	7,957,309,291.00	3,824,524,382.82	4,936,279,958.18	18,087,601,932.00



**БидиСЕК ХК**

ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ

Брокер  
Андеррайтер  
Хөрөнгө оруулалтын зөвлөх

Хаяг: БидиСек ХК,  
Бээжингийн гудамж 27/1,  
8-р хороо, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар хот Монгол улс.

Утас: +976 7555-1919

И-мэйл: [info@bdsec.mn](mailto:info@bdsec.mn)

Вэб: [www.bdsec.mn](http://www.bdsec.mn)

